



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/320

Мөрөн сум

Барилга байгууламж ашиглалтад
оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Мөрөн суманд баригдсан “Соёмбо” цэцэрлэгт хүрээлэн байгуулах төсөл арга хэмжээний барилгын ажлыг хүлээж авах, байнгын ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Н.Шинэбаяр (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын
Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд: Д.Сандагдорж (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн
бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн
мэргэжилтэн, Аймгийн Ерөнхий архитекторын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Г.Ням-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн
хэлтсийн Архивын тасгийн сан хөмрөгийн эрхлэгч)

Х.Тайванбаяр (Мөрөн сумын Засаг дарга)

С.Анхбаяр (Аймгийн Онцгой байдлын газрын Гал түймрийн
хяналтын байцаагч, ахмад)

Д.Мягмарсүрэн (Аймгийн Газрын харилцаа, барилга хот
байгуулалтын газрын Барилга техник хяналтын
улсын байцаагч)

Д.Аюушжав (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Эрчим хүчний
хяналтын улсын байцаагч)

Б.Гал-Эрдэнэ (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл,
харилцаа холбооны хяналтын улсын байцаагч)

Г.Даваадорж (“Хөвсгөл эрчим хүч” ХХК-ийн Ерөнхий инженер)

Д.Сүхээ (“Хөвсгөл ус суваг” ХХК-ийн Ерөнхий инженер)

Э.Сумъяасүрэн (Хөвсгөл Барилга захиалагчийн хяналтын төвийн
хяналтын инженер)

Ш.Нямханд (“Хөвсгөл дулааны станц” ТӨХК-ийн ерөнхий инженер)

Г.Дэлгэрнасан (Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн
Хүртээмж нийгмийн оролцооны мэргэжилтэн)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Т. Баттулга (“Онч тэнхлэг” ХХК-ийн захирал)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

С.Оюунчимэг (“Сант-Өндөр ХХК-ийн” захирал)

6712011009

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Ц.Нацагдорж (Шинэ Мөрөн ӨНӨААТҮГ)

Комиссын нарийн бичгийн дарга:

Э.Аззаяа (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын ахлах мэргэжилтэн)

2.Барилга байгууламжийн ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулж ажиллахыг Комиссын дарга (Н.Шинэбаяр)-т даалгасугай.

3.Барилга байгууламжийн ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Э.Аззаяа) -д үүрэг болгосугай.

4.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР